



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

**“Төрийн орон сууцны корпораци”  
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн  
Төлөөлөн удирдах зөвлөлд  
төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх  
гишүүдийг чөлөөлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 01/3380 дугаар албан бичгийг үндэслэн Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболдыг “Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000716